

**Монголын эрүүгийн процессын хуулийн
өөрчлөлт, шинэчлэлт**

**Amendments and Reform of Mongolia's
Criminal Procedure Law**

Жамбаачүлтэмийн Эрхэсхулан

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор*

*Улаанбаатар хот, Монгол Улс
erkheskhulan@num.edu.mn*



[Товч утга]

Аливаа хуулийн зорилго, агуулга нь тодорхой, ойлгомжтой, хэм хэмжээ хоорондын үйлчлэл нь уялдаж байвал хэрэглэхэд хялбар төдийгүй хэрэгжүүлэхэд алдаа гарах нь бага бөгөөд үүнийг баримтлах нь эрүүгийн процессын хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлтийн үндэс, эрх зүйн хөгжлийн тулгуур байх учиртай. Эрүүгийн процессын хууль тогтоомжид шинэчлэл эрчимтэй хийж буй цаг үед эрүүгийн процессын өнөөгийн хуулийн өөрчлөлттэй холбогдуулж судалгааны тоон баримт, харьцуулалт, кейс зэрэг материалд түшиглэн энэхүү өгүүллийг бичлээ. Хуулийн өөрчлөлт, шинэчлэлт нь хөгжил дэвшлийн шаардлагаар, хууль хоорондын өрсөлдөөн, зөрчлийг засах, хийдлийг арилгах, нэгдмэл утгаар ойлгох, зөв хэрэглээг хангах зорилгоор хийгддэг. Энэ бүхний үр дүн нь тус улсад нийгмийн харилцаанд чанарын дэвшил гарч байх учиртай юм. Үндсэндээ байнгын хөгжил хөдөлгөөн нь өөрчлөлт шинэчлэлтийн үндэс. Тодруулбал, нийгмийн хөгжил нь шинэ, шинэ харилцааг шаардаж энэ хэрээр хууль тогтоомжид зохицуулалт дутагдаж, хийдэл үүсэх байдлаар хуулийн шинэчлэл, өөрчлөлт хийгдэж байх нь зүй тогтол. Тиймээс эрүүгийн процессын хууль болон холбогдох хэм хэмжээний хийдэл, тэдгээрийн өөрчлөлтүүдийг эмпирик түвшинд судалж, дурдсан зүй тогтлын мөн чанарыг нээн илрүүлэх, зохих өөрчлөлтүүд зорилгодоо хүрсэн үү, тогтвортой үйлчилж байна уу, түүний эерэг, сөрөг талууд, эрүүгийн процессын хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгч байна уу гэдэг талаас нь байнгын эрэл хайгуул хийж байх нь судлаач бидний үүрэг. Иймд энэ хүрээнд болон түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үзүүлсэн нөлөө болон онолын шүүх хэмээн нэрлэгдэх хяналтын шатны шүүхийн оролцооны талаар цухас хөндсөн болно. Бүтцийн хувьд 4 бүлэг, санал дүгнэлтийн хэсэгтэй.

[Түлхүүр үг]

Эрүүгийн процессын эрх зүй, эрх зүйн хийдэл, эрх зүйн хэм хэмжээний өөрчлөлт, эрх зүйн шинэчлэлт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, хяналтын шатны шүүх.

I. Эрүүгийн процессын хуулийн тогтвортой байдал, өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйл

Тус улсын ардчилсан тогтолцоонд шилжилтийн цаг үеэс өнөөг хүртэл эрүүгийн процессын хууль тогтоомжид¹ зарчмын шинжтэй өөрчлөлтүүд болон бусад өөрчлөлтүүд удаа дараа хийгджээ. Энэ хүрээнд 1963 оны хуульд орсон 1994 оны нэмэлт өөрчлөлтөөс өнөөг хүртэлх эрүүгийн процессын хуульд хийгдсэн өөрчлөлтүүд хамаарна. Нийгмийн харилцааг хуулиар зохицуулах нь аль ч төрт улсуудын дагаж мөрдөх жишиг журам, харин түүнийг туйлбартай мөрдөх нь олон хүчин зүйлээс хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, хуулийн өөрийн нь тогтвортой байдалд гадаад, дотоод хоёр хүчин зүйлс нөлөөлдөг аж. Гадаад хүчин зүйл нь нийгмийн хөгжил, үндэсний онцлог, үзэл санааны шинэчлэл өөрчлөлт, хөгжингүй орнуудын сайн туршлага, нийтлэг жишиг түгээмэл хандлагууд. Харин дотоод хүчин зүйлийн хувьд хэм хэмжээний тухайн харилцааг зохицуулах чадвар, тохирсон байдал, хэм хэмжээ хоорондын уялдаа, хуулийн дотоод бүтэц, тогтолцоо, системчлэлийн асуудал хамаарна. Эдгээрээс нэн чухал үзүүлэлт бол тухайн харилцаагаа бүрэн дүүрэн илэрхийлэх хэм хэмжээний дотоод агуулга, тэдгээр хэм хэмжээ хоорондын зөрчилгүй байдал, хийдэл²-гүй чанар, хэрэглэхэд ойлгомжтой, тодорхой байх шаардлагууд, түүнчлэн хууль хэрэглээний тухай асуудал юм. Тэдгээр шаардлагуудын хангалтгүй байдлаас үүдэж хууль тогтоомж ойр ойрхон өөрчлөгдөх, хүчингүй болох, шинэчлэгдэх процессууд үргэлжилж байна. Ямар ч улс оронд эрх зүйн хийдэл зохих түвшинд илэрч байдаг.³ Судлаач Р.Онончимэг “Эрх зүй, түүний хийдэл” бүтээлдээ эрх зүйн хийдэл үүсэх үндсэн шалтгааныг объектив ба субъектив шалгаан гэж 2 ангилж⁴ үзээд Академич С.Нарангэрэлийн “Хуулиудын дайн болж, зэрэгцсэн, зөрчилдсөн, тэр ч байтугай бие биеэ үгүйсгэсэн, авцалдаагүй хуулиуд гарч байгаа нь харилцан нэгнийхээ заалтыг саармагжуулж, ямар ч үр ашиггүй болгож байна”⁵ гэж бичсэнийг иш татжээ. Хуулийн өөрчлөлт нь нийгмийн шаардлагаар хийгддэг байх ёстой үзэгдэл, эрх зүйн хөгжлийн илэрхийлэл. Хэт богино хугацаанд

¹ А.Солонго, Монгол улсын эрх зүйн эх сурвалж: онол, системчлэл, зангилаа асуудал, (Улаанбаатар, 2022), 120 дахь тал.

² Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол (III хэвлэл), (Улаанбаатар, 2024), 316 дахь тал.

Р.Онончимэг, Эрх зүй, түүний хийдэл, (Улаанбаатар, 2025), 37 дэх тал.

³ Д.Баярсайхан, “Эрх зүйн хийдэл зөрчилдөөний хэлбэрүүдийг эрүүгийн эрх зүйн хэмжээний зарим жишээн дээр авч үзэх нь”, Хууль дээдлэх ёс, 92 (1), 2023, 14 дэх тал.

⁴ Р.Онончимэг, өмнөх эшлэл 4, 64 дэх тал.

⁵ С.Нарангэрэл, “Монгол улсын эрх зүйн тогтолцооны бүхэллэг (нэгдмэл) байдлыг хадгалах нь”, Хууль дээдлэх ёс, 85 (тусгай дугаар), 2021.

олон тооны өөрчлөлт явагдах нь хууль ёс, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг үгүйсгэх үр дагавартай хэдий ч өөрчлөгдөхгүй байх нь эсрэгээрээ нийгмийн хөгжлийн “чөдөр, тушаа” болох нь бий. Хууль өөрийгөө шинэчилж “цус сэлбэх” үндсэн арга нь нэмэлт өөрчлөлт юм. Үүнээс үзэхэд хуулийн өөрчлөлт нь нийгмийн хөгжлийг урагшлуулагч хүчин зүйл бол хуулийн тогтвортой байдал нь нийгмийн эерэг хандлага, төлөвшлийг бэхжүүлэгч хоёр талтай үзэгдэл юм. Иймд аль ч салбар эрх зүй бүр өөрсдийн хамаарах хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэд дүн шинжилгээтэй хандаж, гарцаагүй өөрчлөлт үү, нийгмийн харилцаанд үр дүнтэй юу гэдэг шалгуурын үүднээс хандах шаардлага байна. Хуулийн өөрчлөлт нь ойлгомжгүй, тодорхойгүй зохицуулалтыг илүү тодорхой болгох, хуулийн үзэл санааг илүү дэлгэрүүлэх, хийдэлтэй байдлыг арилгах, үр ашигтай байдлыг тогтооход чиглэх ёстой. Судалгаанаас үзэхэд эрүүгийн процессын хуулийн өөрчлөлт нь эрх тэгш байдал, хууль ёс, шударга ёсыг тогтоох, төлөвшүүлэхэд чиглэсэн нийгмийн шаардлага, үзэл санааны дэвшил хөгжил, түүнчлэн хүний эрхийг хангахад чиглэсэн хэрэг хянан шийдвэрлэх түргэн шуурхай, чирэгдэлгүй ажиллагаа явуулах процессын шаардлага, шүүхийн практикт үндэслэж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор, түүнчлэн холбогдох бусад хуулийн өөрчлөлттэй уялдуулах зэрэг шаардлагын улмаас хийгддэг байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд тус улсын хувьд дэлхий дахиныг хамарсан цар тахал, ажилгүйдэл ядуурал, инфляц, үнийн хөөргөдөл болон төр засгийн албан тушаалтнуудын хээл хахууль, авлигын хэрэг хэрээс хэтэрч улс орны баялгийг хэдэн цөөн тооны хүмүүс хууль бус аргаар хуваан хүртсэн томоохон гэмт хэргүүдэд ард олны бухимдал үүссэний улмаас холбогдох ял шийтгэлийг шударгаар оногдуулах зүй ёсны нийгмийн шаардлага нь хууль өөрчлөгдөх гадаад хүчин зүйлийн нөлөөлөл болж байжээ.

II. Эрүүгийн процессын хуулийн өөрчлөлт, түүний агуулга

1960-аад оны эхээр *Монгол улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд хамгийн урт удаан хугацаанд тогтвортой үйлчилсэн* Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх хууль батлагдсан. Тус хууль нь зөвхөн Зөвлөлтийн нөлөөлөл гэх тодотголоос илүүтэй Ром-Германы сонгодог хуулийн хэлбэр загвар бүхий шинжлэх ухааны тухайн үеийн ололт байж, энэ ч үүднээсээ Монголын хөрсөнд буулгаж чадсан хууль бол яах аргагүй 1961 оны Эрүүгийн, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль юм. Бид энэхүү сэдвийн хүрээнд шилжилтийн үеийн процессын хууль хийгээд түүний үргэлжлэл болох өнөөгийн хүчин төгөлдөр хууль хүртэлх бүх цаг үеийн эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний өөрчлөлтийг тал бүрээс нь тухайлан судлахыг эрмэлзсэн

бөгөөд тоо, статистикийн хувьд зарим нэгэн андуу ташаа зүйл байхыг үгүйсгэхгүй хэдий ч танилцуулах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

Хүснэгт 1.


Эрүүгийн процессын хуульд орсон өөрчлөлтийн судалгаа
(2025 оны байдлаар)

ЭП хууль Өөрчлөлт 1994 оны нэмэлт өөрчлөлт Өөрчлөлт орсон заалтын тоо		Эрүүгийн Байцаан Шийтгэх хууль-1963		Эрүүгийн байцаан шийтгэх хууль- 2002		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль-2017	
		1994-2001 он хүртэлх өөрчлөлт	2007 оны нэмэлт өөрчлөлт	Бусад өөрчлөлт	2020 оны нэмэлт өөрчлөлт	Бусад өөрчлөлт	
		Өөрчлөлт орсон заалтын тоо	Өөрчлөлт орсон заалтын тоо	Өөрчлөлт орсон заалтын тоо	Өөрчлөлт орсон заалтын тоо	Өөрчлөлт орсон заалтын тоо	
өөрчлөх	Бүлэг, хэсэг, заалтаар өөрчлөн найруулсугай	160	20	61	24	26	47+57=104
	Өөрчилсүгэй /үг,үсэг/	90	0	49	19	27	31+36=67
нэмэх	Бүлэг, хэсэг, заалтаар нэмсүгэй	13	8	41	7	26	14+81=95
	Нэмсүгэй /үг, үсэг/	8	2	33	11	22	11+16=27

хасах	Бүлэг, хэсэг, заалтаар хүчингүй болгосугай	61	0	9	6	6	6+1=7
	Хасагдсан /үг, үсэг/	16	2	8	6	8	1+8=9
Өөрчлөлт орсон нийт заалтын тоо		348	32	201	71	115	110+199=309
		380	272	225+199=424			


Зураг 1.

Эрүүгийн процессын хуульд орсон өөрчлөлтийн тоон үзүүлэлт



Зураг 2.

Эрүүгийн процессын хуульд орсон өөрчлөлтийн бүтэц, хэлбэр
(өөрчлөн найруулсан, шинээр нэмсэн,
хүчингүй болгосон заалтын тоо)



Бидний судалгаагаар 30 шахам жил үйлчилсэн тус хуульд нийгмийн өөрчлөлт, шинэчлэлттэй уялдаж 1994 онд 348 заалтыг хамарсан томоохон нэмэлт өөрчлөлт бусад хугацаанд 32 өөрчлөлт оруулж, 2002 он хүртэл үйлчлэхдээ нийт 380 орчим зүйл заалтын өөрчлөлт хийсэн нь бүхэлдээ шинэ Үндсэн хуульд нийцүүлэх алхам байв. (Зураг 1 ба 2 нь 2024 оны байдлаар) Ийнхүү 2002 оны ЭБШ хууль батлагдах хүртэл 8 жил үйлчлэхдээ гүйцэтгэсэн үүрэг, далайцаараа шинэ нийгмийн харилцаан дэх манай анхны Эрүүгийн процессын бие даасан хууль байжээ. Эдгээр хууль тогтоомжийн үзэл баримтлал нь хүний эрхийг дээдэлсэн шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэх, зах зээлийн нийгэм дэх хүмүүнлэг, иргэний ардчилсан төрийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үндсэн чиглэмжийг тодорхойлж, эрүүгийн хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах явдлыг цогцоор нь хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэхэд оршиж байв. Тодруулбал, шүүгдэгч өөрийн гэм бурууг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй, өөрийн болон гэр бүлийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, саатуулагдсан үеэс өмгөөлөгчөөр хангагдах, хэргийг шалгах явцад эргэлзээ гарвал эргэлзээг хэрэгт холбогдогчид ашигтайгаар шийдвэрлэх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хараат бус, хөндлөнгийн, шударга шүүхээр мэтгэлцээний үндсэн дээр шүүлгэх эрх, шүүхийн шийтгэх тогтоол гартал хэнийг ч гэм буруутайд тооцохгүй байх зэрэг дэвшилтэт, суурь үзэл баримтлал нь

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг бүхэлд нь шинэчлэхэд хүргэсэн ажээ.

Дараагийн харьцангуй тогтвортой үйлчилсэнд тооцогдох 2002 оны ЭБШ хууль 15 жилийн хугацаанд үйлчлэхдээ 2007 онд 201 заалтыг хамарсан томоохон өөрчлөлт бусад хугацаанд 71 өөрчлөлт, нийтдээ 272 өөрчлөлт хийгдсэн байдаг. (Зураг 1 ба 2 нь 2024 оны байдлаар) Эрүүгийн процессын 2002 оны хууль нь шинэ нийгмийн харилцааг бүхэлд нь зохицуулсан анхны бие даасан суурь хууль болохын хувьд нийгмийн шинэ харилцаа бүртэй анх удаагаа нүүр тулсан гэхэд болно. Практик хэрэглээний явцад алдаа оноотой, хийдэлтэй зүйл цөөнгүй ажиглагдсаны зэрэгцээ зохицуулалтыг харилцаа бүрт оновчтой тодорхойлох, оролцогчдын процессын эрх, эрхийн баталгааг илүү төгөлдөржүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уян хатан, нээлттэй, шуурхай байдлыг хангах зүй ёсны шаардлага тулгарсан юм. Тухайлбал энэ хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан оролцогчдын оролцооны байдлыг өргөтгөж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нээлттэй, хамтын зарчмыг хэрэгжүүлэх шинэ агуулгаар баяжуулж, тэдний санал, хүсэлтэд тулгуурласан хэргийг хялбаршуулан журмаар хянан шийдвэрлэх дэвшилтэт тогтолцоог нэвтэрүүлсэн, түүнчлэн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын олонх байгаа газарт хэрэг бүртгэлт явуулах, хойшлуулшгүй ажиллагаа явуулж болох эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинээр нэмж тусгасан зэрэг өөрчлөлт нь эрүүгийн процесс ажиллагаанд чирэгдэлгүй, шуурхай байдлыг хангасны зэрэгцээ хэргийн ачааллыг зохих хэмжээгээр бууруулах бодит алхам болжээ. Хэргийн байдлыг бодитойгоор тогтоох, шударгаар шүүх, шүүлгэх эрхийн хүрээнд нөлөөллийн мэдүүлэг авах, шүүгчдийн зөвлөгөөнөөс хэрэг хувиарлах, шүүх хуралдааныг дуу, дүрс бичлэгээр баталгаажуулах, эвлэрүүлэн зуучлагчийг гэрчээр үл байцаах, мөн өөрийн зардлаар байцаалтын явцыг дүрс бичлэгээр бэхжүүлэх, иргэдийн төлөөлөгч ял болон гэм буруугийн талаар дүгнэлт өгөх үүрэг бүхий байсныг зөвхөн гэм буруугийн талаар санал гаргахаар өөрчлөлт хийсэн нь иргэдийн төлөөлөгчдийн бодит байдалд тохирсон төдийгүй олон улсын жишигт нийцсэн дэвшилтэт шинэ нэмэлт зохицуулалтуудыг тусгажээ. Ийнхүү тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн ихэнх нь эерэг, дэвшилтэт зохицуулалтууд байгаагийн зэрэгцээ хүний эрхийн процессын баталгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, зарчимд үл нийцсэн, эрх зүйн байдлыг дордуулсан үр дагаврыг дагуулсан цөөнгүй хэм шихэмжээ хуульчлагдсаныг дурдах хэрэгтэй. Тухайлбал тус хуульд оруулсан томоохон нэмэлт өөрчлөлт болох 2007 оны 08 сарын 9 өдрийн хуулиар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн

биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол шүүхийн шатнаас шүүхийн өмнөх шатанд буцаах зохицуулалтыг нэрлэж болно. Тус зохицуулалт нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль хэрэгжүүлэгчдийн алдаатай ажиллагааг засаж залруулахад ач холбогдлоо өгөх хэдий ч хөндлөнгийн хараат бус шударга шүүхээр шүүлгэх, гэм буруутай үйлдлийнхээ төлөө зөвхөн 1 удаа шүүлгэх эрх, нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох, эргэлзээг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зэрэг олон улсын гэрээ, пактаар хүлээн зөвшөөрөгдсөн зарчимтай үл нийцэх⁶, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байх зорилгыг алдагдуулсан, гэмт этгээдэд ял завших боломж нөхцөлийг олгосон⁷, хуулийн хэрэгжилт, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх⁸ олон үр дагаврыг бий болгосон юм.

Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалаар боловсрогдсон хүний эрхийн түгээмэл тунхаглал, тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийг эрүүгийн процесс ажиллагаанд бодитой хэрэгжүүлэх явдал нь манай улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг тул хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн үйл ажиллагааны нэгдмэл зорилго болсоор ирснийг онцлох нь зүйтэй. Энэ хүрээнд тодорхой бодитой алхмууд хийгдэх цаг үе тус улсад 2010-аад оноос явагдаж эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн 2-р давлагаатай холбоотой. Үүний үргэлжлэл болж хүн төрөлхтний хөгжлийн дэвшилтэт хандлага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сайн туршлагауудыг нэвтрүүлэх, ажил хэрэг болгох зүй ёсны шаардлага тулгарснаар өмнөх хуулийн практик, туршлага дээр суурилж 2017 оны эрүүгийн процессын хууль анх удаагаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нэртэйгээр шинээр боловсрогдон мөрдөгдсөн билээ. Бидний судалгаагаар тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээсээ хойш 8 жилийн хугацаанд 2020 оны 115 заалтыг хамарсан томоохон өөрчлөлт, бусад хугацаанд 309 өөрчлөлт хийгдэж, нийтдээ 424 өөрчлөлт хийгджээ. (Зураг 1 ба 2 нь 2024 оны байдлаар)


⁶ Ж. Эрхэсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу”, Эрх зүй сэтгүүл, №3, 2020.

⁷ Хэрэг мөрдөн рүү буцсанаас хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн тоон үзүүлэлт

⁸ Тус зохицуулалтыг 2002 оны ЭБШХ-ийн 2007.08.09 нэмэлт өөрчлөлтөөр анх хуульд оруулсан бол 2017 оны шинэ хуульд тусгах эсэх талаар хууль тогтоогчдын дунд ихээхэн маргаан өрнөсний эцэст хуульд тусгахаас татгалзаж, мөн хуулийн 2019.04.15-ний өдрийн нэмэлтээр хуульд тусгагдаж, 2022.06.03 өдрийн хуулиар буцаан хассан байдаг. Ж.Э

Зураг 3.

Эрүүгийн процессын хуульд орсон өөрчлөлтийг баталсан хуулийн тоо




Зураг 4.

2002 болон 2017 оны эрүүгийн процессын хуулиудад орсон өөрчлөлтийн агуулгын ангилал




2002 оны ЭБШХ-ийн өөрчлөлт



- Хуулийн зохицуулалт боловсронгуй болж шинэчлэгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдсэн)
- Найруулгын шинжтэй өөрчлөлт хийгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдээгүй)
- Эрх зүйн байдлыг дордуулсан заалт
- Бусад (шингэр нэмсэн, хассан заалт)

2017 оны ЭХХШГХ-ийн өөрчлөлт



- Хуулийн зохицуулалт боловсронгуй болж шинэчлэгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдсэн)
- Найруулгын шинжтэй өөрчлөлт хийгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдээгүй)
- Эрх зүйн байдлыг дордуулсан заалт
- Бусад (шингэр нэмсэн, хассан заалт)

Дээр дурдсан эдгээр өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд бидэнд байгаа тоон баримтаар 1963 оны ЭБШ хуулийн 1994-2001 онд хамаарах нэмэлт өөрчлөлтийг УИХ-аас хууль гаргах замаар нийт 8 хуулиар, харин 2002 оны ЭБШ хуульд хамаарах өөрчлөлтийг нийт 14 хууль, түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 6 удаагийн шийдвэр (дүгнэлт, тогтоол) гарч түүний хэрэгжилтийг хангах 4 хууль, мөн 2017 оны ЭХХШТХ-ийн өөрчлөлтийг өнөөгийн байдлаар нийт 12 хууль, Үндсэн хуулийн цэцийн 4 удаагийн шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах 3 удаагийн хуулийн үр дүнд хийгдсэн байдал харагдаж байна.⁹ (Зураг 3 нь 2024 оны байдлаар) Үүнээс үзэхэд 2002 оны ЭБШ хуультай харьцуулахад 2017 оны ЭХХШТ хуульд цаг хугацааны хувьд 2 дахин илүү хурдтайгаар өөрчлөлт оруулжээ. Энэ хугацаанд (сүүлийн 8 жил) нийгмийн харилцаа тийм хурдтайгаар өөрчлөгдөв үү гэтэл үгүй, харин ч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тодорхой хугацаанд хорио цээр, зогсонги байдалтай байсан билээ. Энэ байдлаас дүгнэлт хийхэд 2002 оны ЭБШ хууль нь өнөөгийн хуулиас илүү тогтвортой байж, түүхэн үүргээ гүйцэтгэжээ гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Харин 2017 оны ЭХХШТ хууль ийнхүү хурдтайгаар өөрчлөгдсөн нь сайны шинж үү, саарын шинж үү гэдэг нь сонирхол татаж буй юм. Энэ үүднээс 2002 оны ЭБШ хууль болон 2017 оны ЭХХШТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан тухайлсан хуулийн хэм хэмжээ, заалтуудын чанарт харьцуулалт хийж үзсэн болно. Тухайлбал, 2002 оны хуулийн нийт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж үзэхэд өмнөх зохицуулалтаасаа боловсронгуй болж шинэчлэгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдсэн) 43, найруулгын шинжтэй өөрчлөлт хийгдсэн заалт (агуулгын өөрчлөлт хийгдээгүй) 75, эрх зүйн байдлыг илт дордуулсан шинжтэй заалт 4, дурдсан шижүүдийг агуулаагүй бусад заалт 86 байсан бол 2017 оны хуулийн хувьд боловсронгуй болсон заалт 32, найруулгын шинжтэй 52, эрх зүйн байдлыг дордуулсан заалт 6, бусад заалт 80 байна. (Зураг 4 нь 2024 оны байдлаар) Дурдсанаас үзэхэд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон, эрх зүйн байдлыг дээрдүүлсэн шинжтэй өөрчлөлтүүд төдийгүй, эрх зүйн зохицуулалт хийдэлтэй¹⁰, ухралт хийсэн, эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй өөрчлөлтүүд түүнчлэн зөвхөн утга найруулга, үг үсгийн засвар болон бусад хуулийн өөрчлөлтэй нийцүүлсэн өөрчлөлтүүд мөн хийгдсэн байна. Эдгээрээс анхаарал татах зүйл бол эрх зүйн хийдэлтэй, эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалтууд

⁹ МУИС-ийн ХЗС, Нийтийн эрх зүйн тэнхим, “2002 болон 2017 оны хуулиудад оруулсан өөрчлөлтөд хийгдсэн судалгааны үр дүн”, 2023.05, 5 дахь тал.

¹⁰ Д. Лүндээжанцан, Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник, (Улаанбаатар, 2016), 108 дахь тал.

бөгөөд түүний жишээ болгоход, 2017 оны ЭХХШт хуулиар “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа” тохиолдолд яллагдагчийг цагдан хорьж болох үндэслэлтэй байв. Гэтэл уг хуулийн 2020.01.10 өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус заалтыг “гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа” хэмээн өөрчилсөн бөгөөд “болзошгүй” гэх үгийн тодорхойгүй байдлыг ашиглан практикт хүнийг хууль бусаар хорих боломжийг нэмэгдүүлсэн байна. Түүнчлэн нэг заалт хамгийн олон өөрчлөлт хийгдсэн байдалд шинжилгээ хийж үзэхэд иймэрхүү заалтууд 2017 оны хуульд нийтдээ 10 орчим байгаа бөгөөд дунджаар 3-5 хүртэл удаагийн өөрчлөлт хийгджээ. Жишээ нь ЭХХШт хуулийн 33.3.2 дугаар заалтад “хэргийг прокурорт буцаасан шийдвэрт гагцхүү прокурор эсэргүүцэл бичдэг байсан бол эхний нэмэлт өөрчлөлтөөр яллагдагч бичдэг болж, дараагийн нэмэлт өөрчлөлтөөр хохирогч бичдэг болсон байх жишээний. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргах үндэслэл 2020.01.10 өдрийн хууль, 2021.01.15 өдрийн хууль, 2023.06.01 өдрийн хуулиар 3 удаа өөрчлөгдсөний зэрэгцээ, мөн 2002 оны хууль үйлчилж байх үед 2007.08.09 өдрийн хууль, 2014.04.24 өдрийн хуулиар тус тус 2 удаа өөрчлөгдөж байсан зэргийг дурдаж болох юм.

Ш. Эрүүгийн процессын эрх зүйд Цэцийн шийдвэрийн үзүүлсэн нөлөө, үр дагавар

Зураг 2-д үзүүлснээр Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үр дагавраар 2002 оны ЭБШ хуульд нийт 8 өөрчлөлт орсноос зургаа (43.3.7-3.8, 334.4, 396.3-4, 418.2)-н заалтад орсон өөрчлөлт нь оролцогчдын гомдол гаргах эрхийг өргөтгөн сайжруулсан зохицуулалт болж өнөөгийн хуульд уламжлагдаж, эрх зүйн хөгжилд зохих хувь нэмрээ үзүүлсээр байгаа юм. Харин мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй нөхцөлд бусад этгээдээр өмгөөлүүлэх (ЭБШХ-38.2) боломжийг хүчингүй болгосон нь эргэлзээтэй. Тус заалтаар иргэний өөрийгөө өмгөөлөх, өөртөө туслах боломжийг өргөтгөх агуулга илэрхийлсэн атал бусдаар мэргэжлийн өмгөөлөл хийлгэх агуулгаар тайлбарлан тус заалтыг хүчингүй болгосон байдаг. Иргэн өөрийгөө өмгөөлөхөд мэргэжлийн өмгөөлөгчийн шаардлага хамаарахгүйтэй адил тийм эрх зүйн байдлаар бусдаар өөртөө туслуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх эдлүүлэх боломжтой. Тодруулбал, заавал өмгөөлөгч оролцох хэргээс бусад хэрэгт мэргэжсэн өмгөөлөгчийн үйлчилгээ авахыг хүсээгүй иргэд дурдсан боломжийг ашиглаж болох байсан. Үүнтэй төсөөтэй ойлголт бол иргэн, захиргааны эрх зүй дэх итгэмжлэгдсэн төлөөлөгч, хууль ёсны төлөөлөгч юм. Найм дахь өөрчлөлтийн хувьд төрөл садангийн

хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хассан (ЭБШХ-45.7)-аар тус заалт өмнөх 1963 оны ЭБШ хуулийн холбогдох заалттай яг адил болсон байдаг. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үр дагавраар өөрчлөлт хийгдсэн 2002 оны ЭБШ хуулийн дурдсан 2 заалтаас бусад өөрчлөлт нь тухайн хуулийг боловсронгуй болгоход эерэг нөлөө үзүүлжээ хэмээн дүгнэж болно.

2017 оны ЭХХШТ хуулийн хувьд Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үр дагавраар мөн 8 өөрчлөлт орсоноос 39.1.4, 39.9.1.4, 40.8.1.4 заалтуудын өөрчлөлт нь шүүхээс ял хүндрүүлэх зохицуулалтыг хүчингүй болгож, шүүхийг яллах чиг үүргээс ангид байх баталгаа, тус хуулийн 33.3.2 дэх заалтад орсон өөрчлөлт нь оролцогч (хохирогч)-ийн шүүхийн өмнөх тэгш эрхийг баталгаажуулж өгснөөрөө дэвшилттэй зохицуулалт болжээ. Харин тус хуулийн 33.4.1.3-р заалтыг Үндсэн хуулийн Цэцийн 2021.05.12 өдрийн 04 дүгнэлтээр түдгэлзүүлснээс хойш өнөөг хүртэл шийдвэрлээгүй нь эрх зүйн зохицуулалтгүй, тодорхойгүй байдалд оруулаад байна. Хамгийн сүүлийн байдлаар 2023.05.03 өдрийн Үндсэн хуулийн Цэцийн 02 дүгнэлтээр “анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” болон “шүүх хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” тохиолдол (ЭХХШТ хуулийн 40.1.1.1, 40.1.1.3 болон 40.5.2)-д хяналтын гомдол, эсэргүүцэл хүлээн авах, Улсын Дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэхээр хуульчилсан нь иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн гэж үзжээ. Энэхүү дүгнэлтийг УИХ хүлээн авч 2016.06.16 өдрийн хуулиар “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах”, “хуулийг Улсын Дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн” хэмээн өөрчлөлт оруулсан боловч мөн чанартаа хүчингүй болсон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн байх вий гэхээс эмээж байна. Хөндөж буй сэдвийн хүрээнд Үндсэн хуулийн Цэцийн доорх шийдвэрүүдийг онцлон танилцуулахыг хүсэж байна. Үүнд:

Жишээ 1. 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар “хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдхүүнд иргэдийн төлөөлөгч таслах эрхээрээ оролцох” нь Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн Цэцийн 2013.11.13 өдрийн 04 дүгнэлт, 2014 оны 01 тогтоолоор Үндсэн хуулийг зөрчсөнийг тогтоож, хүчингүй болгож шийдвэрлэсэн нь эх газрын тогтолцоот тус улсын эрүүгийн процесс ажиллагааны үндсэн хэв маягийг хадгалсан жишиг тогтоосон шийдвэр болжээ. Тухайн үеийн хууль тогтоогчдын ойлголтын зөрүүг үндэстэй тайлбарлаж тодруулбал, “хэрэг маргааныг хамтын журмаар хянан шийдвэрлэх”,

“хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн”-ний зааг ялгааг нэг мөр шийдвэрлэж чадсанаараа ач холбогдолтой юм.

Жишээ 2. 2006 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6-р зүйлд заасан УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь эсхүл гэмт хэргийн газарт нь эд мөрийн баримттай баривчилсан тохиолдолд л бүрэн эрхийг нь түдгэлзүүлж, гэмт хэрэгт шалгаж, хуулийн хариуцлага хүлээлгэж болох зохицуулалт нь Үндсэн хууль заасан “иргэн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг зөрчсөн эсэх маргааныг 2011.10.21 өдрийн 03 дүгнэлт, 2012.02.15 өдрийн 02 тогтоолоор Үндсэн хуулийг зөрчсөнийг тогтоож, хүчингүй болгож шийдвэрлэсэн нь Их хурлын гишүүний халдашгүй байдал (иммунитет) болон иргэний хууль шүүхийн өмнө эрх тэгш байх суурь эрхийн зарчмын ялгааг тогтоож өгснийг зэрэгцээ хүчингүй болгосон заалтыг агуулгаар нь дахин сэргээх нь хууль тогтоогч хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаа зөрчиж буйг тогтоож өгсөн байна. Энэ маргаанд бүтэн 10 жил зарцуулсны эцэст дээрх хүчингүй болсон заалт дангаар үйлчлэх боломжгүй харин хууль тогтоогчоос 2010 онд “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн” гэх заалтыг хассан нь алдаа болохыг хүлээн зөвшөөрүүлж, хоёр заалт хослон үйлчилсэн тохиолдолд л Үндсэн хуулийн зөрчилгүй болох жишгийг тогтоожээ.

Жишээ 3. 2020.01.10 өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөнтэй холбогдож 2017.07.01 өдрөөс 2020.01.10 өдрийн хооронд мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгосон хэргүүдийг сэргээн шалгах, мөн шатанд шалгагдаж байгаа хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, үүнтэй уялдаж мөн эрүүгийн хуульд заасан “эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх, эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх” хуулийн зохицуулалт үйлчлэхгүй тухай “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хууль батлагдсан нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан үүсгэсэн. Хууль ёсны шүүхээр хянан шийдвэрлэж цагаатгасан, хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг парламентаас хууль гаргах замаар сэргээн шалгах нь шүүх эрх мэдэлд халдсан хэрэг болохыг түүнчлэн эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны үүднээс гэмт хэрэгт холбогдогчийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг хэрэглэхгүй байх олон улсын суурь зарчмын үйлчлэл нь мөн аль нэг улсын парламентаас гаргасан хуулийн хоригоор зогсох учиргүйг Үндсэн хуулийн Цэцийн 2020.12.25 өдрийн 12-р дүгнэлт, 2021.06.11 өдрийн 01-р тогтоолоор тус тус тогтоож Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, холбогдох

хуулийг хүчингүй болгож шийдвэрлэсэн нь хууль тогтоогчдын алдааг залруулсны зэрэгцээ, олон иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж чаджээ. Үүнд:

Судалгаанаас үзэхэд шүүхийн шатанд 2017.07.01 - 2020.01.10 хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн нийт 63 хэргийг сэргээснийг хүчингүй болгожээ. Мөн 2017.07.01 - 2020.12.25 хооронд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хянан шийдвэрлэгдэж байсан хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоосныг хүчингүй болгож, тэдгээр хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолж (эрх зүйн байдлыг дордуулсан шинэ заалтыг хэрэглэхгүй, өмнөх заалтыг баримталсан) хэргийг шийдвэрлэх болжээ. Хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүсгэсэн нь Улсын Дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргахад хүргэсэн байна. Эдгээр байдлаас дүгнэвэл Үндсэн хуулийн Цэц нь эрх зүйг хөгжүүлэгч төдийгүй хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд үр нөлөөтэй субъект болох нь харагдаж буй юм.

IV. Хяналтын шатны шүүхийн үүрэг, оролцоо

Үндсэн хуульд Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс мөн гэж заасан. Иймээс Үндсэн хуулийн бүтцэд багтсан байгууллагууд нийт улс орны хэмжээнд үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж ажиллах нь үүрэг бөгөөд энэхүү байдал нь гагцхүү эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлаар хэрэгжинэ. Ийнхүү төрийн нэгдмэл хүсэл зориг нь эрх зүйн нэгдмэл тогтолцоо болох тухай Кельзений суурь хэм хэмжээний онолын илрэл юм. Эрх зүйн тогтолцоо нь онолын хувьд позитив эрх зүйн нэгдсэн системчлэл, ойлголт, ухагдахууны нэгдмэл тайлбар нь дээд хүчин чадал бүхий нэг цөм хэм хэмжээнд нэгдсэн, түүнээс эх сурвалжаа болгосон тохиолдолд нэгдмэл байх боломжтой. Энэ хүрээнд Монгол улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт, 2021 оны Шүүхийн тухай хууль болон процессын хуулийн өөрчлөлтүүд хийгдсэн билээ. *Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт «Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана» гэж заасан.* Шүүхээр хэлэлцэгдэж буй маргааны шийдвэр нь эрх зүйн хөгжилд үр нөлөө үзүүлэх, хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой тохиолдолд хяналтын гомдлыг хүлээн авах шүүлтүүр тавьдаг нь олон улсын жишиг юм.¹¹ “Хууль

¹¹ М. Фэтэрис, “Европт дээд шүүх эрх зүйг хөгжүүлсэн нь”, Эрх зүй сэтгүүл, 62 (2), 2023, 474-482 дахь тал.

бүтээх (law-making) буюу эрх зүйг хөгжүүлэх (development of law) явдал нь зөвхөн хууль тогтоогчийн ажил үүрэг бус, харин шүүхийн ч гэсэн ажил үүрэг гэдгийг өнөөдөр олон улс оронд нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөх болов.¹² Энэ талаар хууль зүйн ухааны доктор Ц.Цогт “...шүүгч хууль хэрэглэх замаар зохицуулалтын хийдэл, өөр хоорондоо зөрчилтэй хэм хэмжээг илрүүлэх, түүнийг хууль санаачлах боловсронгуй болгох эрх үүрэг бүхий зохих байгууллага, албан тушаалтнуудад уламжлах замаар шийдвэрлэх боломжтой, ... шүүгч нар тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх явцад тухайн хууль зүйн фактыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх боломжит бүхий л эрх зүйн эх сурвалжуудыг судалж, хэрэглэгдэх эрэмбэ дараа, хүчин төгөлдөр байдал зэргийг нарийвчлан шалгадаг учир ...хэрэв тухайн маргаан, нийгмийн харилцааны асуудлыг шийдвэрлэх хууль зүйн гарц гаргалгаа зохицуулалт дутсан тохиолдолд хуульч, шүүгч соргогоор мэдрэх, олж илрүүлэх боломжтой”¹³ гэжээ. Үүнээс үзэхэд дээд шүүх тухайн маргааны хууль зүйн үндэслэлийн талаар дэлгэрэнгүй тайлбар өгөх замаар эрх зүйг хөгжүүлэх боломжтой төдийгүй шүүхийн нэгдмэл практикийг тогтоох нь иргэдийн хууль ёс, шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх ач холбогдолтой. Тус улсад УДШ-ээс хууль тайлбарлах практик эртнээс уламжлалтай бөгөөд өнөөгийн байдлаар 2002 оны ЭБШ хуульд 7 тайлбар, 2017 оны ЭХХШт хуульд 6 тайлбар гаргасан байна. Хууль тайлбарлах нь хуулийн логик холбооны бодит илэрхийлэл буюу дотоод уялдаа, агуулгын харилцан хамаарал, нийцлийг тодорхойлж буй онол арга зүйн үндэслэл юм. Хуулийн зохицуулалт, өөрчлөлтийн үйл явцаас тайлбар хоцорвол нэгдмэл ойлголт дутагдаж хуулийг буруу ойлгох, зөрүү хэрэглэх улмаар үр ашиггүй олон удаагийн өөрчлөлт хийхэд хүргэж байгааг анхаарах нь зүйтэй юм.

V. Дүгнэлт, санал

Судалгаанаас үзэхэд Эрүүгийн процессын хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн дийлэнх нь 1-рт хууль санаачлагчийн өргөн барьснаар, 2-рт харилцан уялдаа бүхий бусад хуульд хийгдсэн өөрчлөлтөд нийцүүлэх 3-рт иргэдийн өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үр дагавраар хийгджээ. Тэдгээрт дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл голлох үүрэгтэй нь харагдав. Эндээс дүгнэхэд:

а. Дотоод хүчин зүйлийн хувьд эрх зүйн тодорхойгүй байдлыг

¹² Neil MacCormick and Robert Summers eds., *Interpreting Precedents (A Comparative Study)*, (Ashgate/Dartmouth, 1997), 531-535.

¹³ Ц. Цогт, “Эрх зүйн хийдэл, түүнийг шийдвэрлэх арга зам (эсээ)”, <https://legaldata.mn/b95#!>, 2023

даван туулахын тулд эрх зүйн тогтолцооныхоо мөн чанарыг орчин үеийн шаардлага, хүний эрхийн стандартад зохистойгоор уялдуулах замаар онол арга зүйн нэгдмэл хандлагаар хуулийг боловсруулах, нэн ялангуяа эрх зүйн бүлийн ижил төстэй орнуудын сайн туршлага, онол арга зүйг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

б. Хуулийн өөрчлөлт, шинэчлэлт нь түүний хөгжлийг илэрхийлэх үзүүлэлт мөн хэдий ч үр дагавар нь нийгэм, иргэдэд ач холбогдолтой байж ахиц дэвшилд хүргэх учиртай. Гэтэл хэдэн зуун өөрчлөлт хийгдэж, бүр сүүлийн жилүүдэд хурд нь 2 дахин ихсэх мөртлөө Үндсэн хуулийн Цэцээр хянагдах алдаа, засвар нь мөн л 2 дахин нэмэгдсээр байгаа практик нь ядуурал, авлига, популист улс төр, шударга бус, тэгш бус байдал зэрэг нийгмийн гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр онолын үндэслэл муутай хуулийн өөрчлөлт хийсний үр дагавар болох нь тодорхой байна.

Иймд хууль тогтоомжийг их өөрчилсөндөө бус онол арга зүйн үндэслэлтэй, судалгаатай хийх нь үр ашигтай төдийгүй эрүүгийн процессын эрх зүйд шинэчлэл авчрах учиртай. Эрүүгийн процессын хуульд хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд зөрчил хийдэл цөөнгүй байгаа, шийдэл хүлээсэн байдал хуульд дараагийн томоохон реформын шинжтэй цогц өөрчлөлт хийх шалтгаан хийгээд суурь хэдий нь бүрджээ. Ийнхүү өөрчлөлтөд УДШ, Үндсэн хуулийн цэц, УИХ-ын харилцан хяналттай, хамтын шуурхай ажиллагаа л чухал үүрэгтэй болох нь харагдлаа.

Жишээ нь Эрүүгийн хуулийг “буруу хэрэглэх”, “зөрүү ойлгох” гэсэн ойлголтууд 2021 оны 1 дүгээр сараас маргаан дагуулсан билээ. Учир нь “буруу, зөрүү” гэдэг нь хоршил хослол юм уу, аль эсхүл хэзээ, хаана, юунд гомдол гаргаж байгаагаас утга агуулга нь ойлгогдох учиртай зүйл заалт юм уу, энэ мэт ойлгомжгүй зохицуулалт практик хэрэглээнд эргэлзээ төрүүлсээр байна. Зөрүү гэх ойлголт нь эерэг талаасаа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор хийсэн өөрчлөлт мэт боловч нөгөө талаасаа хэрэглээг амарчлах эсхүл хянан шийдвэрлэх гомдол эсэргүүцлийн тоог багасгах гэсэн хардлага дагуулах юм. Түүнчлэн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн алдаатай шийдвэрийг хэвээр баталсан бол яах вэ, зөрүүгүй учраас хүлээж авахгүй байх уу. Хууль хэрэглээн дээр зөрүү, буруу хоёрыг хэрхэн ялган тайлбарлаж, хэрэглэх вэ, энд тайлбар шаардлагатай байна. Энэ асуудлаар хуулийн заалтыг түдгэлзүүлсэн Үндсэн хуулийн шийдвэр гарч, УИХ-аас хүлээн зөвшөөрч хууль гаргасан хэдий ч агуулгаар нь дахин сэргээсэн байх магадлал нь түүхийг давтаж, ахин маргаан өрнүүлэхгүй гэх баталгаа алга байна.

Сүүлийн үед харьцангуй ихээр яригдах болсон хууль хэрэглээний

нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг хяналтын шатны шүүхийн чиг үүрэг гарцаагүй мөн. Гэвч хуулийг “зөрүү ойлгох, буруу хэрэглэх” гэх ойлголтоо тойрон эргэлдсээр... Тэдэнд эрх зүйг хөгжүүлэх дараагийн үүрэг бийг мартаж болохгүй. Харин ч Үндсэн хуулийн Цэц сүүлийн жилүүдэд хэдэн жинтэй шийдвэрээрээ эрх зүйг хөгжүүлэх үүрэг гүйцэтгэлээ гэж бодож байна.

Нийгмийн практикт олон маргаан мэтгэлцээн өрнөж, шийдвэрлэгдэхгүй удааширч байгаа нь хууль тогтоомжийн ойлгомжгүй, тодорхойгүй, хэрэглээний нэгдмэл бус байдалтай шууд хамааралтайгаас гадна олон тооны хийгдсэн өөрчлөлт нь “байгаа оноогүй”-с ахин дахин өөрчлөгддөгтэй холбоотой. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хууль тайлбарлах ажиллагаа нийгмийн өөрчлөлт, хуулийн шинэчлэлтийн хурдыг гүйцэх шаардлага тулгарч буй нь онолын шүүхээс “ханцуй шамлан” ажиллахыг шаардах боллоо.

[Ном зүй]

Амаржаргалын Солонго *Монгол улсын эрх зүйн эх сурвалж: онол, системчлэл, зангилаа асуудал*, Улаанбаатар, 2022 он.

Должингийн Баярсайхан, *Эрх зүйн онол*, Улаанбаатар, 2010 он.

Должингийн Баярсайхан, *Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн шинэтгэлийн асуудлууд*, Улаанбаатар, 2018 он.

Должингийн Баярсайхан, “Эрх зүйн хийдэл зөрчилдөөний хэлбэрүүдийг эрүүгийн эрх зүйн хэмжээний зарим жишээн дээр авч үзэх нь”, *Хууль дээдлэх ёс*, 92 (1), 2023 он.

Данзангийн Лүндээжанцан, *Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник*, Улаанбаатар, 2016 он.

Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу”, *Эрх зүй сэтгүүл*, №3, 2020 он.

Маартэн Фэтэрис, “Европт дээд шүүх эрх зүйг хөгжүүлсэн нь”, *Эрх зүй сэтгүүл*, 62 (2), 2023 он.

Ренчиндоржийн Онончимэг, *Эрх зүй, түүний хийдэл*, Улаанбаатар, 2025 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, “Монгол улсын эрх зүйн тогтолцооны бүхэллэг (нэгдмэл) байдлыг хадгалах нь”, *Хууль дээдлэх ёс*, 85, 2021 он.

Цэндийн Цогт, “Эрх зүйн хийдэл, түүнийг шийдвэрлэх арга зам (эсээ)”, <https://legaldata.mn/b95#!>, 2016 он.

Чойжилын Нямсүрэн, *Эрх зүйн ерөнхий онол* (III хэвлэл), Улаанбаатар, 2024 он.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №45, 2019 он.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №07, 2006 он.

Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021 он, №04, 2021 он.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1963 он.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №26, 2002 он.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №18, 2017 он.

МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхим, “2002 болон 2017 оны хуулиудад оруулсан өөрчлөлтөд хийгдсэн судалгааны үр дүн”, 2023.05.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн холбогдох дүгнэлт, тогтоолууд. Erwin Chemerinsky & Laurie L. Levenson, *Criminal Procedure* (2nd edition), 2013.

MacCormick, N., & Summers, R. (Eds.), *Interpreting Precedents: A Comparative Study*, Ashgate/Dartmouth, 1997.

[Abstract]

**Amendments and Reform of Mongolia's
Criminal Procedure Law**

Erkheskhulan Jambaachultem

Doctor of Laws (Ph.D.).

Professor at the Public Law Department

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

The purpose and content of any law must be clear and comprehensible, and the interaction among its legal norms must be coherent. When these requirements are met, the law is not only easier to apply but also less prone to errors in implementation. Adherence to these principles should constitute the foundation of amendments and reforms to criminal procedural legislation and serve as a cornerstone of legal development. At a time when reforms to criminal procedural legislation are being actively pursued, this article has been written on the basis of empirical data, comparative analysis, and case materials relating to amendments to the current criminal procedure law. Amendments and reforms to the law are undertaken in response to the demands of social progress, with the aim of addressing conflicts and competition between laws, eliminating legal gaps, ensuring uniform interpretation, and promoting correct application. The ultimate outcome of such reforms should be qualitative improvement in social relations within the state. Fundamentally, continuous development and change form the basis of legal reform. More specifically, social development gives rise to new forms of social relations, which in turn expose regulatory deficiencies and legal gaps, making legislative amendments and reforms an inherent and regular process. Accordingly, it is the responsibility of legal scholars to continuously examine, at an empirical level, the gaps in criminal procedural law and related legal norms, as well as the amendments made thereto; to identify the underlying nature of these patterns; to assess whether the relevant amendments have achieved their intended objectives and function in a stable manner; to evaluate their positive and negative aspects; and to determine whether they effectively contribute to the realization of the objectives of criminal procedural law. Within this framework, the article also briefly addresses the impact of decisions of the Constitutional Court,

as well as the role and involvement of Supreme Court, often referred to as “theoretical courts.”.

[Keywords]

Criminal Procedural Law, Legal Gaps, Amendment of Legal Norms, Legal Reform, Law on Criminal Procedure, Constitutional Court Decisions, Supreme Court.